



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/78/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Д.Бямбасүрэн

Утас: 70272287 Цахим хаяг: byambasurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/129
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН МӨНГӨНМОРЬТ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ж.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн А/02 дугаар тушаалаар бүтэц орон тоо 23 байхаар баталж үйл ажиллагааг явуулж ажилласан байна. Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, хэрэгжүүлэх 78 арга хэмжээтэй баталснаас нийт 87.6%-тай дүгнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 119,660.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 4,313.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,920.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 15,110.6 мянган төгрөгийн дуусаагүй барилга, 72,547.9 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийт 221,551.5 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 72,568.0 мянган төгрөгийн зам гүүрний барилга байгууламж, 4,562.5 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, Хүнс, Хөдөө аж ахуйн газраас 162,181.8 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 458,095.5 мянган төгрөгийн зам гүүрний барилга байгууламж шилжүүлэн авч үндсэн хөрөнгө данс 697,407.8 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Мөнгөнморьт сумын ИТХ 2022 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор 25,922.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,411.7 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 30,009.3 мянган төгрөгийн зам гүүрний барилга байгууламж, 11,000.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө акталж устгах, 260,000.0 мянган төгрөгийн дуусаагүй барилга, 13,000.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,753,971.02	71,526,622.92
33	АВЛАГА	8,000,000.00	0
33500	Бусад авлага	8,000,000.00	0
33510	Байгууллагаас авах авлага	8,000,000.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	65,753,971.02	71,526,622.92
35100	Түүхий эд материал	440,000.00	440,000.00
35130	Эм боох материал	440,000.00	440,000.00
35400	Хангамжийн материал	57,813,971.02	58,586,622.92
35410	Бичиг хэргийн материал	12,330,900.00	4,451,000.00
35420	Аж ахуйн материал	41,755,062.52	42,758,752.52
35430	Сэлбэг хэрэгсэл	0	850,000.00
35440	Түлш, шатах тослох материал	8.5	1,895,670.40
35470	Бусад хангамжийн материал	3,728,000.00	8,631,200.00
35600	Мал амьтад	7,500,000.00	12,500,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,411,235,580.63	2,804,592,879.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,411,235,580.63	2,804,592,879.09
39200	Биет хөрөнгө	2,369,022,247.33	2,763,265,546.05
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,284,969,965.00	1,294,969,965.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-238,026,365.74	-298,696,330.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	419,203,307.00	701,045,123.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-218,278,808.82	-258,939,561.96
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	189,438,314.20	167,829,314.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-102,777,674.85	-110,125,044.19
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,041,777.02	87,550,643.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	-52,500,499.61	-63,110,120.12
39209	Зам, гүүрийн байгууламж	260,768,479.00	761,422,696.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-123,041,648.28	-110,054,580.72
39214	Бусад үндсэн хөрөнгө	956,698,832.96	1,009,809,222.96
39215	Хуримтлагдсан элэгдэл	-355,473,430.55	-433,546,381.66
39216	Дуусаагүй барилга, байгууламж	260,000,000.00	15,110,600.00
39300	Биет бус хөрөнгө	42,213,333.30	41,327,333.04
39301	Програм хангамж	3,780,000.00	3,780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,470,666.70	-3,356,666.96
39303	Бусад биет бус хөрөнгө	40,904,000.00	40,904,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,484,989,551.65	2,876,119,502.01
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	9,034,309.00	4,653,089.92
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,034,309.00	4,653,089.92
41300	Өглөг	9,034,309.00	4,653,089.92
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,143,960.00	42,489.92
41360	Бусад өглөг	6,890,349.00	4,610,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг	6,890,349.00	0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0	4,610,600.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,475,955,242.65	2,871,466,412.09
51	Засгийн газрын хувь оролцоо	2,475,955,242.65	2,871,466,412.09
51100	Засгийн газрын оруулсан капитал	667,794,348.38	667,794,348.38
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	667,794,348.38	667,794,348.38
51200	Хуримтлагдсан үр дүн	1,607,152,099.59	2,002,663,269.03
51210	Өмнөх үеийн үр дүн	1,367,441,992.04	1,607,152,099.59
51220	Тайлант үеийн үр дүн	239,710,107.55	395,511,169.44
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	201,008,794.68	201,008,794.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,484,989,551.65	2,876,119,502.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,330,941,658.80	1,794,093,091.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	120,159,136.00	702,857,853.00
120	Нийтлэг татварын бус орлого	120,159,136.00	702,857,853.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	88,770,996.00	697,407,853.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	31,388,140.00	5,450,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,210,782,522.80	1,091,235,238.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,919,422.80	75,185,838.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	6,117,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,815,447.80	21,987,836.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,103,975.00	47,080,302.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,115,863,100.00	1,016,049,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,115,863,100.00	1,016,049,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,013,229,981.15	1,398,082,522.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	872,192,858.35	833,436,965.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	831,659,854.91	686,565,200.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	241,633,056.29	223,137,468.43
210101	Үндсэн цалин	156,632,708.29	94,599,054.91
210102	Нэмэгдэл	41,423,892.00	14,381,197.57
210104	Урамшуулал	0	3,639,957.40
210105	Гэрээт ажлын хөлс	43,576,456.00	110,517,258.55
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,460,315.64	28,210,873.09
210201	Тэтгэврийн даатгал	22,136,770.38	19,515,612.64
210202	Тэтгэмжийн даатгал	2,351,053.38	2,291,012.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,881,222.20	1,812,649.68
210204	Ажилгүйдлийн даатгал	457,919.59	402,011.17
210205	Эрүүл мэндийн даатгал	4,633,350.09	4,189,586.87
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,083,619.91	72,302,677.94
210301	Гэрэл, цахилгаан	9,829,520.91	11,537,392.54
210302	Түлш, халаалт	50,462,624.00	51,442,629.00
210303	Цэвэр, бохир ус	9,791,475.00	9,322,656.40
2104	Хангамж, бараа материалын зардал	44,050,703.91	52,744,027.70
210401	Бичиг хэрэг	4,863,820.38	10,579,300.00
210402	Тээвэр, шатахуун	32,331,383.90	34,766,747.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,545,889.63	3,600,316.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,309,610.00	3,797,664.20

2105	Нормативт зардал	89,421,890.00	0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	47,221,240.00	0
210502	Хоол, хүнс	25,095,340.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,105,310.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,918,589.00	0
210604	Урсгал засвар	5,918,589.00	0
2107	Томилолт, зочны зардал	1,958,000.00	3,315,000.00
210702	Дотоод албан томилолт	1,958,000.00	3,315,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,988,394.00	4,350,369.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,654,150.00	2,787,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0	604,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	582,144.00	377,475.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	335,300.00	416,694.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	416,800.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	333,145,286.16	302,504,784.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,617,255.00	48,401,539.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	247,424,031.16	254,103,244.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,533,003.44	146,871,765.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,300,000.00	40,026,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	33,686,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	6,339,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	39,233,003.44	106,845,665.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,233,003.44	75,061,966.23
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	31,783,698.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	141,037,122.80	564,645,557.00
2200	Дотоод эх үүсвэрээр	141,037,122.80	564,645,557.00
221001	Их засвар	141,037,122.80	564,645,557.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	317,711,677.65	396,010,569.28
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	78,001,570.10	499,399.84
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	69,854,380.10	499,399.84
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	8,147,190.00	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	239,710,107.55	395,511,169.44

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,210,782,522.80	1,091,235,238.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,210,782,522.80	1,091,235,238.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	94,919,422.80	75,185,838.80
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0	6,117,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	69,815,447.80	21,987,836.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,103,975.00	47,080,302.80
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,115,863,100.00	1,016,049,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,115,863,100.00	1,016,049,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	499,431,529.00	593,744,971.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	499,431,529.00	593,744,971.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	458,898,525.56	446,873,206.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,352,888.00	201,127,464.65
210101	Үндсэн цалин	154,352,540.00	157,349,546.13
210102	Нэмэгдэл	41,423,892.00	33,433,110.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0
210104	Урамшуулал	0	3,248,052.40
210105	Гэрээт ажлын хөлс	43,576,456.00	7,096,755.43
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	0	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,460,315.64	24,659,788.72
210201	Тэтгэврийн даатгал	22,136,770.38	17,127,438.29
210202	Тэтгэмжийн даатгал	2,351,053.38	1,985,659.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,881,222.20	1,558,707.92
210204	Ажилгүйдлийн даатгал	457,919.59	362,856.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,633,350.09	3,625,126.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,063,619.91	76,004,935.54
210301	Гэрэл, цахилгаан	9,829,520.91	11,537,392.54
210302	Түлш, халаалт	50,222,624.00	51,442,629.00
210303	Цэвэр, бохир ус	10,011,475.00	13,024,914.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,071,989.01	25,822,016.00
210401	Бичиг хэрэг	4,596,820.38	2,224,400.00
210402	Тээвэр, шатахуун	19,123,379.00	16,797,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,353,989.63	3,600,316.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,997,800.00	3,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,499,589.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	3,499,589.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,958,000.00	2,755,000.00
210702	Дотоод албан томилолт	1,958,000.00	2,755,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,099,528.00	33,983,309.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,160,484.00	32,420,140.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	582,144.00	377,475.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	335,300.00	416,694.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	416,800.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,392,596.00	81,020,692.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	67,288,596.00	81,020,692.86
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	104,000.00	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,533,003.44	146,871,765.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,300,000.00	40,026,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	33,686,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	6,339,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	39,233,003.44	106,845,665.03
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,233,003.44	75,061,966.23
213404	Хөрөнгийн	0	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0	31,783,698.80
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	711,350,993.80	497,490,267.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	711,350,993.80	497,490,267.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	711,350,993.80	497,490,267.00
2200	Дотоод эх үүсвэрээр	711,350,993.80	497,490,267.00
220001	Барилга байгууламж	0	119,815,600.00
221001	Их засвар	45,330,650.00	120,000,000.00
223001	Бусад хөрөнгө	197,622,043.80	34,122,577.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	468,398,300.00	223,552,090.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-711,350,993.80	-497,490,267.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	667,794,348.38	201,008,794.68	1,367,441,992.04	2,236,245,135.10
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	667,794,348.38	201,008,794.68	1,367,441,992.04	2,236,245,135.10
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	239,710,107.55	239,710,107.55
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	667,794,348.38	201,008,794.68	1,607,152,099.59	2,475,955,242.65
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	667,794,348.38	201,008,794.68	1,607,152,099.59	2,475,955,242.65
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	667,794,348.38	201,008,794.68	1,607,152,099.59	2,475,955,242.65
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	395,511,169.44	395,511,169.44
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	667,794,348.38	201,008,794.68	2,002,663,269.03	2,871,466,412.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,016,049,400.00	940,987,433.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	497,769,500.00	443,497,166.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	463,083,300.00	408,811,166.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,342,200.00	201,127,464.65
210101	Үндсэн цалин	164,830,500.00	157,349,546.13
210102	Нэмэгдэл	44,511,700.00	33,433,110.69
210104	Урамшуулал	0	3,248,052.40
210105	Гэрээт ажлын хөлс	0	7,096,755.43
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,261,300.00	24,659,788.72
210201	Тэтгэврийн даатгал	19,887,500.00	17,127,438.29
210202	Тэтгэмжийн даатгал	2,093,500.00	1,985,659.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,674,700.00	1,558,707.92
210204	Ажилгүйдлийн даатгал	418,800.00	362,856.60
210205	Эрүүл мэндийн даатгал	4,186,800.00	3,625,126.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,673,600.00	63,350,858.54
210301	Гэрэл, цахилгаан	12,703,700.00	11,537,392.54
210302	Түлш, халаалт	54,720,000.00	51,442,629.00
210303	Цэвэр, бохир ус	249,900.00	370,837.00
2104	Хангамж, бараа материалын зардал	23,995,700.00	23,943,716.00
210401	Бичиг хэрэг	1,276,000.00	1,224,400.00
210402	Тээвэр, шатахуун	16,019,700.00	16,019,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,500,000.00	3,499,616.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	3,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,757,300.00	2,755,000.00
210702	Дотоод албан томилолт	2,757,300.00	2,755,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	46,896,700.00	33,983,309.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,813,300.00	32,420,140.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,300.00	604,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	645,600.00	377,475.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	416,700.00	416,694.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	416,800.00	165,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,656,500.00	57,491,029.86
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,656,500.00	57,491,029.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,686,200.00	34,686,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,686,200.00	34,686,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,686,200.00	33,686,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	999,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	518,279,900.00	497,490,267.00
220001	Барилга байгууламж	365,095,500.00	343,367,690.00
221001	Их засвар	120,000,000.00	120,000,000.00
223001	Бусад хөрөнгө	33,184,400.00	34,122,577.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,016,049,400.00	1,016,049,400.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	497,769,500.00	1,016,049,400.00
320001	Орон нутгийн төсвөөс	497,769,500.00	1,016,049,400.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	518,279,900.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	518,279,900.00	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,402,140.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,402,140.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,062,040.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,654,077.00
210303	Цэвэр, бохир ус	12,654,077.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,878,300.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	777,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,529,663.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,529,663.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,340,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,340,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,340,100.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	75,185,838.80
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,185,838.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,830,816.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	39,355,022.80

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газар нь төрийн хуулийг дээдлэн хүндэлж иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй, ил тод, нээлттэй хүргэн ард иргэдийнхээ амьжиргааны түвшин дээшлүүлэх замаар сум орон нутгаа хөгжүүлэхэд оршино гэсэн зорилт тавин ажилласан байна.

Төв Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн А/02 дугаар тушаалаар бүтэц орон тоо 23 байхаар баталж үйл ажиллагааг явуулж ажилласан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт, хэрэгжүүлэх 78 арга хэмжээтэй баталснаас нийт 87.6%-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зарим заалтад 2022 оны 4 дүгээр сарын 29-ний, 2022 оны 7 дугаар сарын 01-ний, 2022 оны 8 дугаар сарын 29-ний, 2022 оны 12 дугаар сарын 9-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой зарим заалтад 2022 оны 4 дүгээр сарын 29-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуулийн зарим заалтуудад 2022 оны 4 дүгээр сарын 22, 7 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн "Дотоод хяналтын зөвлөл шинэчлэн батлах тухай" А/15 тушаалаар томилж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулсан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын дотоод хяналтын зөвлөл нь тайлант онд дотоод хяналт шалгалтыг улирлаар төлөвлөн хэрэгжилтийг гарган ажилласан байна.

Тус байгууллагад тайлант онд аймгийн Санхүү хяналт, дотоод аудитын албанаас санхүүгийн баримтад хяналт шалгалт хийгээгүй байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/22 тоот захирамжаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажилласан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 391,130.0 мянган төгрөгөөр буюу 15,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	8,000.0		-8,000.0
Бараа материал	65,754.0	71,526.6	5,772.7
Үндсэн хөрөнгө	2,411,235.6	2,804,592.9	393,357.3
Нийт хөрөнгө	2,484,989.6	2,876,119.5	391,130.0
Өр төлбөр	9,034.3	4,653.1	-4,381.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,475,955.2	2,871,466.4	395,511.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,484,989.6	2,876,119.5	391,130.0

Дээрх хүснэгтээс харахад: Тайлант онд авлага дансны эхний үлдэгдэл 8,000.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг буюу 8,000.0 мянган төгрөгөөр буурсан байна. Бараа материал дансны эхний үлдэгдэл 65,754.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 71,526.6 мянган төгрөг буюу худалдан авсан хөрөнгө 5,772.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 2,411,235.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 2,804,592.9 мянган төгрөг болж, 393,357.3 мянган төгрөгөөр буюу төсвийн хөрөнгөөр худалдан авсан 223,552.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 697,407.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, 342,343.0 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10,000.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 119,660.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 4,313.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,920.0 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 15,110.6 мянган төгрөгийн дуусаагүй барилга, 72,547.9 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө нийт 221,551.5 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 72,568.0 мянган төгрөгийн зам гүүрний барилга байгууламж, 4,562.5 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, Хүнс, Хөдөө аж ахуйн газраас 162,181.8 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 458,095.5 мянган төгрөгийн зам гүүрний барилга байгууламж шилжүүлэн авч үндсэн хөрөнгө данс 697,407.8 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Мөнгөнморьт сумын ИТХ-ын 2022 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор 25,922.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,411.7 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл, 30,009.3

мянган төгрөгийн зам гүүрний барилга байгууламж, 11,000.0 мянган төгрөгийн бусад хөрөнгө акталж устгах, 260,000.0 мянган төгрөгийн дуусаагүй барилга, 13,000.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Тайлант онд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 9,034.3 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 4,653.1 мянган төгрөг болж 4,381.2 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлын үлдэгдлээр өр үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,871,466.4 мянган төгрөг болж 395,511.2 төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 495,075.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар тогтоолоор сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны зардлыг 495,075.5 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын зардалд 518,279.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,013,355.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Мөнгөнморьт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны 2022 оны 8 дугаар сарын 08-ны өдрийн 08 дугаар тогтоолоор үйл ажиллагааны зардлыг 2,694.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 497,769.5 мянган төгрөг, 2022 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн 02 дүгээр тогтоолоор шилжих үлдэгдлийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,016,049.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр байна. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,016,049.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 75,062.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 940,987.3 мянган төгрөг буюу 92,6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 12,649.3 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээний зардлыг 13,661.1 мянган төгрөг, баг, хорооны үйл ажиллагааны зардлыг 4,598.1 мянган төгрөг, бусад хөрөнгийн зардлыг 20,789.7 мянган төгрөг, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 23,362.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-үндсэн үйл ажиллагааны зардал	279,056.6	266,407.3	12,649.3	95.5
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-гэрээгээр гүйцэтгэх ажил үйлчилгээ	50,458.5	36,797.4	13,661.1	72.9
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-баг хорооны үйл ажиллагааны зардал	45,405.7	40,807.6	4,598.1	89.9
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	34,686.2	34,686.0	0.2	100.0
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-бусад хөрөнгийн зардал	518,279.9	497,490.2	20,789.7	96.0
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Орон нутгийн нөөц хөрөнгө	5,000.0	4,999.2	0.8	100.0
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Улсын их баяр наадмын зардал	5,000.0	5,000.0	0.0	100.0
8	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал	74,962.5	51,599.7	23,362.8	68.8
9	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага- Хур хог хаягдал, орчны бохирдлын зардал	3,200.0	3,200.0	0.0	100.0
	Дүн	1,016,049.4	940,987.4	75,062.0	92.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд урь оны үлдэгдэл 19,902.4 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны орлого 13,485.9 мянган төгрөг, түймрийн хохирлын орлого 1,187.9 мянган төгрөг, улс төрийн албан хаагчийн тэтгэмжийн санхүүжилт 5,340.1 мянган төгрөг, карт захиалгын орлого 310.0 мянган төгрөг, өвс тэжээлийн орлого 8,083.5 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зудын гамшгийн зардалд 10,000.0 мянган төгрөг, статистикийн зардал 2,651.5 мянган төгрөг, тендерийн орлого 735.0 мянган төгрөг, усны орлого 10,224.0 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 66.0 мянган төгрөг, үнэт цаасны орлого 97.8 мянган төгрөг, хөдөө аж ахуйн тооллогын урамшуулал 2,322.0 мянган төгрөг, шүлхийн санхүүжилт 777.6 мянган төгрөг, бусад 2.1 мянган төгрөг нийт 75,185.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газар тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар усны хэвийн үйл ажиллагааг хангах зардалд 1,200.0 мянган төгрөг, болзошгүй эрсдэлийн зардалд 5,788.1 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 66.0 мянган төгрөг, шатахууны зардалд 12,021.0 мянган төгрөг, шүлхийний зардалд 3,177.9 мянган төгрөг, өвс, тэжээлийн үнэнд 5,825.0 мянган төгрөг, переваз засварлах ажилд 4,890.3 мянган төгрөг, хөдөө аж ахуйн тооллогын зардалд 4,973.5 мянган төгрөг, усны үнэнд 120.0 мянган төгрөг, улс төрийн албан хаагчийн тэтгэмжийн зардалд 5,340.1 мянган төгрөг, бусад зардалд 0.2 мянган төгрөг нийт 43,402.1 мянган төгрөг зарцуулж, 31,783.7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/						
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2022.01.01-2022.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 4 зорилт, хэрэгжүүлэх 78 арга хэмжээ хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт 92,6%	1,016,049.4	940,987.3

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын шилэн данстай холбоотой өгөгдсөн зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Бямбасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 06/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан 2022 оны төсвийг, суурь үзүүлэлтийг төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны 497,759.5 мянган төгрөгийн батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаас 1,5 хувиар буюу 7,466.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 5,599.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газар нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийхэд 82,0 хувь, 5,0 саяас дээших орлогын 32 гүйлгээ, зарлагын 32 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 23 шийдвэр, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 39 мэдээлэл байршуулахаас 633,917.9 мянган төгрөгийн орлогын 26 гүйлгээ байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар зориулалт бус зарцуулалттай холбоотой 2 төлбөрийн акт, цахим төлбөрийн баримт, өр, авлага, шилэн данс, нэмэлт дансны зарцуулалттай холбоотой 4 албан шаардлага, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн Төв аймгийн Мөнгөнморьт сумын Засаг даргын тамгын газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 06/41 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	3,199.0	2	3,199.0	100
Албан шаардлага	4	371,432.6	4	371,432.6	100
Зөвлөмж	2	1,651.6	2	1,651.6	100
Нийт дүн	8	376,283.2	8	376,283.2	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагад дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 789,185.3 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 789,185.3 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: 1.Тус байгууллага тайлант онд санхүүгийн байдлын тайлан дахь хөрөнгийн дүнг 227,877.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2.Тус байгууллага тайлант онд мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийг 20,631.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

3.Тус байгууллага тайлант онд орлого үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 540,676.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 648,903.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 14,985.9 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт тогтоож, 633,917.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1.Тус байгууллага тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орсон газрын дуудлага худалдааны 13,485.9 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5-д “төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх”, 23 дугаар зүйлийн 23.11-т “Газар, байгалийн баялгийн нөөцийг хуульд заасан хэлбэрээр эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдон бий болох орлого нь төсвийн орлого байна” Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал газрын харилцааны талаар дараах нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

2.Тус байгууллага тайлант онд харуул хамгаалалт, үйлчлэгч нарын хувцас 1,500.0 мянган төгрөгөөр худалдан авсан зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Илрүүлэлт:

1. Тус байгууллага тайлант онд шилэн дансны цахим сайтад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээших 633,917.9 мянган төгрөгийн үнийн дүн бүхий орлогын 26 мөнгөн гүйлгээ байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж:Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 10 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/	
							Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллага тайлант онд санхүүгийн байдлын тайлан дахь бараа материал, үндсэн хөрөнгө дүнг зөрүүтэй тайлагнасан	1	227,877.7	1	227,877.7			1	227,877.7
Тус байгууллага тайлант онд мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийг зөрүүтэй тайлагнасан байна	1	20,631.6	1	20,631.6			1	20,631.6
Тус байгууллага тайлант онд орлого үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу тайлагнасан байна	1	540,676.0	1	540,676.0			1	540,676.0
Дүн	3	789,185.3	3	789,185.3			3	789,185.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон газрын дуудлага худалдааны орлогыг орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй.	1	13,485.9	1	13,485.9		
Харуул хамгаалалт, үйлчлэгч нарын хувцас худалдан авсан.	1	1,500.0	1	1,500.0		
Нийт дүн	2	14,985.9	2	14,985.9		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансанд 5,0 саяас дээших орлогын 26 гүйлгээ байршуулаагүй.	1	633,917.9			1	633,917.9
Дүн	1	633,917.9			1	633,917.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 7 аж ахуй нэгж, 5 иргэнээс хандив тусламж авсан						
Дүн						
Нийт дүн	1	633,917.9			1	633,917.9

